МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 02 өдөр Дугаар А/67. Мөрөн сум

Орлого бүрдүүлэх, өр, авлагыг бууруулах
талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн орлогын төлөвлөгөөг сард нь багтаан бүрдүүлж шаардлагатай зардалд зарцуулах, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийг цаг хугацаанд нь олгох, өр авлагыг барагдуулах зорилгоор цалин хөлс, нэмэгдэл урамшуулал болон ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл, татварын холбогдох тооцоог сар бүрийн 20-ны дотор тогтмол шилжүүлж байх, 2021 оны жилийн эцэст нийгмийн даатгалын шимтгэл, татварын өртэй гарсан аж ахуйн нэгж, байгууллагууд татвар, шимтгэлийн тооцоог барагдуулж дуусгах, цалин хөлс, нэмэгдэл, урамшил болон ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл, холбогдох татварын тооцоог "Санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн журам"-д заасан дараалыг баримтлан эхний ээлжинд шилжүүлж байхыг шат шатны төсөв захирагчид болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын дарга, захирлуудад тус тус үүрэг болгосугай.

2. Сумын татварын болон нийгмийн даатгалын байцаагч нарт татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төлөвлөгөөний дагуу сард нь багтаан бүрдүүлж, хуваарилж байх талаар холбогдох чиглэл, үүрэг даалгавар өгч ажиллахыг аймгийн Татварын хэлтэс (Ч.Хуншагай), Нийгмийн даатгалын хэлтэс (Л.Юмжирдулам), сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Төрийн сангийн төлбөр тооцоог захирамжийн 1 дэх заалтад дурдсан дараалын дагуу гүйцэтгэх ажлыг зохион байгуулахыг ажиллахыг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Гантулга)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар)-т үүрэг болгосугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2022